

УАНС НЭЗСС - Бүсийн – Монгол улс – ХААН Банк

Улс:	МОНГОЛ УЛС
Төслийн дугаар:	50959
Бизнесийн салбар:	Санхүү (Банк)
Мэдэгдлийн төрөл:	ХУВИЙН
Байгаль орчны нөлөөллийн ангилал:	
Захирлуудын зөвлөлийн хурлын тов:	2019 оны 9 дүгээр сарын 4
Төлөв байдал:	Судлагдаж буй
ТХББ-ийг нийтэд ил болгосон өдөр:	

Төслийн танилцуулга

Уур амьсгалын ногоон сан (“УАНС”) – Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх үйлчилгээ (“НЭЗСҮ”) Бүсийн санхүүжилтийн хүрээнд ХААН банк ХХК-д 60 сая ам.доллар хүртэлх хамтарсан зээл олгох асуудлыг судалж байна. Үүний 45 сая ам.доллар хүртэлх эх үүсвэрийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”) үлдсэн 15 сая хүртэлх хэмжээний эх үүсвэрийг УАНС тус тус санхүүжүүлнэ.

Төслийн зорилго

Зээлийн зориулалт нь НЭЗСҮ-г Монгол улсад хэрэгжүүлэх Бодлогын Мэдэгдэлд заасан стандарт болон шаардлагад нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи нэвтрүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх.

Шилжилтийн нөлөөлөл

Төслийн хүрээнд өндөр үзүүлэлттэй “уур амьсгалын” технологи, шийдлүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрээр санхүүгийн зуучлагчдыг хангаж, тухайн төрлийн зээлийг дамжуулах олгоход шаардлагатай нөү-хау нэвтрүүлэх зорилготой. Улмаар байгаль орчны хувьд тогтвортой, нүүрстөрөгчийн хий бага ялгаруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засагт шилжих үйл явцыг дэмжих юм.

Харилцагчийн мэдээлэл

ХААН Банк ХХК

ХААН Банк нь Монгол улсын хамгийн том арилжааны банк бөгөөд 2018 оны эцэст тус банкны нийт хөрөнгө нь 3.4 тэрбум ам.доллар, зээлийн багцын хэмжээ 1.6 тэрбум ам.доллар, өөрийн хөрөнгийн хэмжээ 0.37 тэрбум ам.долларт хүрсэн байна. Тус банк нь Монгол улс даяар нийт 530 гаруй салбар тооцооны төвөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдагас 80 орчим хувь нь хөдөө орон нутагт байрлаж, Монгол улсын нийт айл өрхийн 75%-ийг нь банк санхүүгийн

үйлчилгээ (хадгаламж ба зээлийн бүтээгдэхүүн) -ээр хангаж байна.

ЕСБХБ-ны санхүүжилт

45,000,000.00 ам.доллар

Төслийн нийт өртөг

60,000,000.00 ам.долларын хамтарсан санхүүжилт

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

Санхүүгийн байгууллага (БОНБ 2014) хэмээх ангилалд багтдаг Хаан банк нь ЕСБХБ-ны харилцагч бөгөөд ЕСБХБ-ны Үйл ажиллагааны шаардлагын 2, 4 болон 9 дүгээр зүйл ангийн шаардлагыг үндсэнд нь хангасан “Байгаль орчны бодлого болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрддөг. Хаан банк нь Үйл ажиллагааны шаардлагын 2, 4, 9 дүгээр зүйлийн нөхцөлийг тогтмол хангаж, шаардлага хангасан байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны тайлан болон төслийн хүрээнд санхүүжүүлсэн дэд төслүүд, тэдгээр нь хэрхэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад нөлөөлж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй талаарх тайлангуудыг жил тутам гаргаж Санхүүгийн Байгууллагуудын Тогтвортой Байдлын Индекс системээр дамжуулан Банкинд танилцуулах үүрэгтэй. Монгол улсад хэрэгжүүлэх НЭЗСҮ-гээр дамжуулан санхүүжилт авсан зээлдэгч нар нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн стандартын үндэсний шаардлага мөн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологийн төслүүд нь Бодлогын Мэдэгдэлд заасан Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны шалгууруудыг тус бүр хангасан байх ёстой. ЕСБХБ-ны гэрээт Зөвлөх нь дэд төслүүд эдгээр шаардлагуудыг хангасан байдлыг ХААН Банкинд мэдэгдэнэ.

Техникийн хамтын ажиллагаа

Уг төсөл нь 6 сая ам.долларын Техникийн хамтын ажиллагааны үр шимийг хүртэх бөгөөд үүний 2 сая ам.долларыг УАНС-гаас санхүүжүүлнэ. Техникийн хамтын ажиллагааны зорилго нь ХААН Банк болон бусад Хамтрагч санхүүгийн байгууллагууд (“ХСБ”)-ын чадавхыг бэхжүүлэх, маркетинг, холбогдох төслүүдийг үнэлэх болон ерөнхий хяналт дүн шинжилгээ хийх, тайлагнах үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.

ААН-ийн холбоо барих мэдээлэл

Холбогдох албан тушаалтан: Байгууллагын банк хариуцсан дэд захирал Б.Эрдэнэдэлгэр

Цахим шуудангийн хаяг: erdenedelger.b@khanbank.com

Утас: +976 11 332 333; +976 70 117 023

Вэб хуудас: www.khanbank.com

Хаяг: ХААН Банк, ХААН Банк цамхаг, Чингисийн өргөн чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг, Улаанбаатар хот 17010, Монгол Улс.

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар тус харилцагч ААН-тэй холбогдоно уу.

Ерөнхий лавлагаа

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах:

Утас: +44 20 7338 7168; Fax: +44 20 7338 7380

Цахим шуудангийн хаяг: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (“ОНМБ”)

Олон нийтийн мэдээллийн бодлого (“ОНМБ”) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн нийтэд ил тод болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог.

[ОНМБ-ын бичвэр](#)

Төслийн гомдлын газар (“ТГГ”)

ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаанаас хэн нэгэнд ямарваа хор хохирол учруулсан, эсвэл учруулж болзошгүй талаар нэг буюу түүнээс дээш тооны хувь хүн болон албан байгууллагын зүгээс мэдүүлсэн өргөдөл гомдлыг хараат бус байдлаар нэг бүрчлэн хянах, барагдуулах боломжийг олгох үүднээс Төслийн гомдлын газар (“ТГГ”)-ыг үүсгэн байгуулсан.

[ТГГ-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх Дотоод журам](#) | [Орос хэл дээрх хувилбар](#)

ТГГ-т мэдүүлэх аливаа өргөдөл гомдлыг ЕСБХБ-ны санхүүжилтийн сүүлийн хуваарилалт хийгдсэнээс хойш 12 сарын дотор гаргах ёстой. Хэрэв та өргөдөл гомдлоо ямар хугацаанд хэрхэн гаргах талаар тодруулахыг хүсвэл ТГГ-ын ажилтантай холбогдох (pcm@ebrd.com хаягаар) болон ЕСБХБ-ны төлөөлөгчийн газарт хандан туслалцаа авч болно.